



I-III/2021

Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 09



Улсын хэмжээнд 2021 оны эхний улиралд 17.6 мянган эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 911 (4.9%)-ээр буурсан байна. Амаржсан эхчүүдийн 13.3 мянга (75.3%) нь 6, түүнээс дээш удаа жирэмсний хяналтад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 567 (4.1%)-гоор буурчээ. Нийт амаржсан эхчүүдийн 48 (0.3%) нь гэртээ төрсөн нь өмнөх оны мөн үеэс 26 (35.1%)-гаар буурсан байна.


Хүснэгт 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III	<u>2021 I-III</u> 2020 I-III	%
Амаржсан эх	18 556	18 235	18 530	17 619	95.1	
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	13 804	13 584	13 839	13 272	95.9	
Гэрийн төрөлт	68	74	74	48	64.9	
Амьд төрсөн хүүхэд	18 671	18 352	18 663	17 752	95.1	
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	18 123	17 730	17 995	17 074	94.9	
Төрөлхийн гажигтай төрсөн	132	146	163	141	86.5	
2500 граммаас доош жинтэй төрсөн	846	786	890	703	79.0	
Амьгүй төрсөн хүүхэд	97	107	101	93	92.1	
Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох)	5	6	5	5	-	

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Улсын хэмжээнд 2021 оны 3 дугаар сард 6316 эх амаржиж, өмнөх сараас 747 (13.4%)-гоор нэмэгджээ. Амаржсан эхчүүдийн 4782 (75.7%) нь 6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдаж, өмнөх сараас 530 (12.5%)-аар нэмэгдсэн байна. Амаржсан эхчүүдийн 18 (0.3%) нь гэртээ төрсөн бөгөөд өмнөх сараас 4 (18.2%)-өөр буурсан байна.

Зураг 1. Амаржсан эх, төрсөн хүүхэд, сараар, 2020-2021 он




Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Эрүүл мэндийн яамны “Төрөлтийн цахим бүртгэл”-ээр 2021 оны 3 дугаар сард 6182 эх амаржиж, 6259 хүүхдэд регистрийн дугаар олгожээ. Нийт төрсөн хүүхдийн 3231 нь эрэгтэй, 3028 нь эмэгтэй, 152 нь ихэр, хүүхдийн дундаж жин 3418 грамм, дундаж өндөр 50.9 см байна.


Амаржсан эхчүүдийг насны бүлгээр харвал, 4.3 хувь нь 20 хүртэлх насных, 91.6 хувь нь 20-39 насных, 4.1 хувь нь 40-өөс дээш насныхан байна.

Амаржсан эхчүүдийн 1.4 хувь нь боловсролгүй, 3.9 хувь нь бага, 12.3 хувь нь суурь, 36.2 хувь нь бүрэн дунд, 5.7 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 39.0 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 1.5 хувь нь магистр, докторын зэрэгтэй байна. Амаржсан эхчүүдийн 54.7 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулсан, 43.8 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй, 1.5 хувь нь гэрлэлтээ цуцлуулсан байна.

Зураг 2. Амаржсан эх, насны бүлэг, дүнд эзлэх хувиар, дүнд эзлэх 2021 оны 3 дугаар сар



Зураг 3. Амаржсан эхийн боловсролын түвшин, хувиар, 2021 оны 3 дугаар сар



Эх үүсвэр: ЭМЯ-ны төрөлтийн цахим бүртгэл

Тайлбар: Энэхүү мэдээлэл нь ЭМЯ-ны захиргааны мэдээллээс тайлагнасан хугацааны хувьд өөр учир зөрүүтэй болно.

Улсын хэмжээнд 2021 оны эхний улиралд 17.8 мянган хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 911 (4.9%)-ээр буурсан байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 17.1 мянга (96.2%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан бөгөөд өмнөх оны мөн үеэс 921 (5.1%)-ээр буурчээ. Нийт амьд төрөлтийн 141 (0.8%) нь төрөлхийн гажигтай, 703 (4.0%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 5 ногдож байна.

Харин 2021 оны 3 дугаар сард 6357 хүүхэд амьд төрсөн нь өмнөх сараас 733 (13.0%)-аар нэмэгджээ. Нийт амьд төрсөн хүүхдийн 6073 (95.5%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан нь өмнөх сараас 670 (12.4%)-аар нэмэгдсэн байна. Нийт амьд төрөлтийн 43 (0.7%) нь төрөлхийн гажигтай, 253 (4.0%) нь 2500 граммаас бага жинтэй байна. Амьгүй төрөлтийн түвшин 1000 нийт төрөлтөд 6 ногдож байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний улиралд нас баралтын 3769 тохиолдол бүртгэгдсэний 1028 (27.3%) нь эмнэлэгт, 2741 (72.7%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх оны мөн үеэс 187 (4.7%)-гоор, гэрийн (бусад газарт) нас баралт 63 (2.2%)-аар, эмнэлгийн нас баралт 124 (10.8%)-өөр тус тус буурчээ.

Хүснэгт 2. Нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III	$\frac{2021 \text{ I-III}}{2020 \text{ I-III}}$ %
Нас баралт	4 342	4 304	3 956	3 769	95.3
Эмнэлэгт нас баралт	1 210	1 318	1 152	1 028	89.2
Гэртээ (бусад газарт)	3 132	2 986	2 804	2 741	97.8
Эхийн эндэгдэл	5	4	9	1	11.1
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	332	317	278	215	77.3
Нялхсын эндэгдэл	281	268	225	187	83.1
Нярайн эндэгдэл	176	156	137	140	102.2
Эхийн эндэгдлийн харьцаа	27	22	48	6	-
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин	18	17	15	12	-
Нялхсын эндэгдлийн түвшин	15	15	12	11	-
Нярайн эндэгдлийн түвшин	9	9	7	8	-

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Энэ оны 3 дугаар сард нас баралтын 1381 тохиолдол бүртгэгдсэний 380 (27.5%) нь эмнэлэгт, 1001 (72.5%) нь гэрийн (бусад газарт) нас баралт байна. Нийт нас баралт өмнөх сараас 144 (11.6%)-өөр, гэрийн нас баралт (бусад газарт) 90 (9.9%)-ээр, эмнэлгийн нас баралт 54 (16.6%)-өөр тус тус нэмэгджээ.


Эхийн эндэгдэл 2021 оны эхний улиралд 1 болж, өмнөх оны мөн үеэс 8 (9.0 дахин)-аар буурчээ. Эхийн эндэгдлийн харьцаа (100 000 амьд төрөлтөд ногдох) 6 болж, өмнөх оны мөн үеэс 9.0 дахин буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний улирлын байдлаар нийт нас баралтын 5.7 хувийг 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 87.0 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 74.9 хувийг нярайн эндэгдэл эзэлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 215 болж, өмнөх оны мөн үеэс 63 (22.7%)-аар, нялхсын эндэгдэл 187 болж, 38 (16.9%)-аар тус тус буурч, харин нярайн эндэгдэл 140 болж, 3 (2.2%)-аар нэмэгдсэн байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2021 оны эхний улиралд 12 болж, өмнөх оны мөн үеэс 3-аар, нялхсын эндэгдлийн түвшин 11 болж, 1-ээр буурч, нярайн эндэгдлийн түвшин 8 болж, 1-ээр нэмэгдсэн байна.

Харин энэ оны 3 дугаар сард тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 11 болж, өмнөх сартай адил, нялхсын эндэгдлийн түвшин 10 болж, 1-ээр нэмэгдэж, харин нярайн эндэгдлийн түвшин 7 болж, адил түвшинд байна.

Зураг 4. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2021 оны эхний улиралд 11.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1897 (20.1%)-гоор нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 7238 (604.2 дахин)-аар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III	$\frac{2021 \text{ I-III}}{2020 \text{ I-III}}$ %
Халдварт өвчнөөр өвчлөгчид	9 590	10 155	9 434	11 331	120.1
Вирус хепатит	129	118	119	45	37.8
Сүрьеэ	854	860	876	574	65.5
Салхин цэцэг	2 215	2 936	1 579	76	4.8
Гар, хөл, амны өвчин	788	389	185	79	42.7
Цусан суулга	790	892	397	104	26.2
Тэмбүү	1 611	1 361	1 942	1 028	52.9
Гонококкт халдвар	1 172	1 361	1 517	874	57.6
Трихомониаз	1 125	1 036	1 422	744	52.3
ХДХВ/ДОХ	5	2	2	3	150.0
Мөөгөнцөр	382	427	1 106	433	39.2
Коронавируст халдвар	-	-	12	7 250	604.2 ¹

¹ Дахин

Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Харин салхин цэцгээр өвчлөгчид 1503 (95.2%)-аар, цусан суулгаар өвчлөгчид 293 (73.8%)-аар, вирус хепатитаар өвчлөгчид 74 (62.2%)-аар, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 106 (57.3%)-аар, трихомониазаар өвчлөгчид 678 (47.7%)-аар, мөөгөнцрөөр өвчлөгчид 673 (60.8%)-аар, сүрьеэгээр өвчлөгчид 302 (34.5%)-аар, тэмбүүгээр өвчлөгчид 914 (47.1%)-аар, гонококкт халдвар 643 (42.4%)-аар буурчээ.

Энэ оны 3 дугаар сард нийт халдварт өвчний 7104 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх сараас 4886 (3.2 дахин)-гаар нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 4430 (4.9 дахин)-аар, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 36 (3.4 дахин)-аар, сүрьеэгээр өвчлөгчид 120 (84.5%)-аар, гонококкт халдвараар өвчлөгчид 119 (58.0%)-аар, тэмбүүгээр өвчлөгчид 120 (42.0%)-аар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин мөөгөнцрөөр өвчлөгчид 86 (52.4%)-гаар буурсан байна.


Улсын хэмжээнд 2021 оны 3 дугаар сард ХДХВ/ДОХ-ын 3 тохиолдол илэрч, нийт бүртгэгдсэн тохиолдол 314 болжээ.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Дэлхийн хэмжээнд 2020 оны 1 дүгээр сараас 2021 оны 3 дугаар сард коронавирусын өвчлөлийн тохиолдол 223 улсад нийт 127.9 сая бүртгэгдэж, 2.8 сая хүн нас баржээ.

Коронавирусын өвчлөлийн тохиолдол 2021 оны 3 дугаар сард дэлхийн 213 улсад 14.5 сая бүртгэгдэж, өмнөх сараас 3.3 сая (29.4%) тохиолдлоор нэмэгдэж, нас баралтын тохиолдол 271.6 мянга бүртгэгдэж, өмнөх сараас 34.7 мянга (11.3%)-аар буурчээ.


Зураг 5. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөл, нас баралтын тохиолдол, сараар, 2020-2021 он




Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Коронавирусын өвчлөлийн нийт тохиолдлыг дэлхийн улс орнуудын бүс нутгаар, 2021 оны 3 дугаар сарын байдлаар харвал Америкийн бүс нутаг хамгийн их буюу 43.6 хувь, хамгийн бага нь Номхон далайн баруун бүсийн орнууд 1.5 хувь эзэлж байна.

Зураг 6. Дэлхийн хүн амын коронавирусын өвчлөлийн тохиолдол, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар сар



Зураг 7. Дэлхийн хүн амын коронавирусын нас баралтын тохиолдол, бүс нутгаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар сар




Эх үүсвэр: ДЭМБ-ын мэдээлэл

Коронавирусын нас баралтын нийт тохиолдлын 48.0 хувь нь Америкийн бүс нутгийн орнуудад, хамгийн бага нь Номхон далайн баруун бүсийн орнуудад 1.1 хувь бүртгэгджээ.

Коронавирус Монгол Улсад


Монгол Улсад 2021 оны 3 дугаар сарын байдлаар коронавирусын нийт 8465 тохиолдол бүртгэгдсэний 4920 (58.1%) нь эдгэрсэн байна. Нийт тохиолдлын 427 (5.0%) нь зөөвөрлөгдсөн, 8038 (95.0%) нь дотоодод тархсан халдвар байна.

Зураг 8. Коронавирусын тохиолдлын тоо, сараар, 2020-2021 он



Эх үүсвэр: ЭМЯ-ны захиргааны мэдээлэл

Зураг 9. Коронавирусын тохиолдлын тоо, насны бүлэг, хүйсээр, 2021 оны 3 дугаар сар



Харин энэ оны 3 дугаар сард коронавирусын 13 зөөвөрлөгдсөн, 5545 дотоодод тархсан халдвар, нийт 5558 тохиолдол илэрсэн нь өмнөх сараас 4430 (4.9 дахин)-аар нэмэгджээ. Коронавирусын нийт тохиолдлын 2631 (47.3%) нь эрэгтэй, 2927 (52.7%) нь эмэгтэй байна. Насны бүлгээр харвал 20-44 насныхан 2768 (49.8%), 45-аас дээш насныхан 1484 (26.7%), 0-19 насныхан 1306 (23.5%) байна.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Амьгүй төрөлт: Жирэмсний 22 долоо хоног ба түүнээс хойших хугацаанд, 500 граммаас дээш жинтэй төрсөн нярайд амьдын шинж тэмдгийн аль нь ч (зүрхний цохилт, судасны лугшилт, булчингийн хөдөлгөөн) илрэхгүй байгааг хэлнэ.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.

Амьгүй төрөлтийн түвшин (1000 нийт төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд нийт төрсөн хүүхдийн тоог амьгүй төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны сарын мэдээ

Ангилал, код: Өвчний олон улсын ангилал /ICD-10/.

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 5 дугаар сарын 17

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805*

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
статистикч Г.Урангоо
Утас : (976-51)-263966*

